



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Цусны нөөц бүрдүүлэх тухай

Донорын тухай хуулийн 21 дүгээр зүйл, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/69 дүгээр тушаал, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1.9, Төвийн Ерөнхий захирлын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/13 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн зэрэгт шилжиж ажиллах үеийн цус цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор “Оюу толгой” ХХК-ний Өмнөговь аймаг дахь уурхайн цогцолборт зохион байгуулах “Дусал цус-Дүүрэн амьдрал” аяны удирдамжийг 1 дүгээр хавсралт, цусны нөөц бүрдүүлэх багийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт, багийн ажиллах чиг үүргийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. “ДУСАЛ ЦУС-ДҮҮРЭН АМЬДРАЛ аяныг удирдамжийн дагуу зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг Багийн ахлагч, Донор зохион байгуулалтын тасгийн их эмч (Б.Ижилбаатар)-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор (С.Алтаннамар)-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР



“ДУСАЛ ЦУС-ДҮҮРЭН АМЬДРАЛ” АЯНЫ УДИРДАМЖ

Сайн дурын, авлагагүй цусны донорын хөдөлгөөнийг сурталчлах, цусны донорын эгнээг өргөжүүлэх, өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн зэрэгт шилжиж ажиллах үеийн цус цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэхэд оршино.

Хамрах хүрээ

Оюу толгой ХХК-ний Өмнөговь аймаг дахь уурхайн цогцолборын ажиллагсад

Хугацаа

2024 оны 03 дугаар сарын 18- 21-ний өдрүүдэд

Зохион байгуулагч:

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Донор зохион байгуулалтын тасаг

Хамтран зохион байгуулагч:

Оюу толгой ХХК, ЦССҮТ-ийн бусад алба, тасаг


Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

№	Цаг	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн
03 сарын 18-ны өдөр			
1.	07.00 -08.10	Хөшигтийн хөндийн нисэх буудлаас Өмнөговь аймгийн Оюу толгой ХХК-ний Уурхай цогцолбор руу Б.Ижилбаатар эмчээр ахлуулсан 16 хүний бүрэлдэхүүнтэй ажиллагсад хөдөлнө.	Алсын явуулын баг
2.	11.00-18.00	Цус цуглуулах бэлтгэл ажил хийгдэнэ /Цус цуглуулах цэгүүдтэй танилцах, бэлтгэлийг хангах, доноруудад мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх/	
03 сарын 19-21ний өдрүүдэд			
1.	06.00-12.00	Цус цуглуулах үйл ажиллагаа /Өдөрт 200-250 нэгж цус цуглуулна. /	Алсын явуулын баг
2.	13.00-14.10	Бүтээгдэхүүн агаарын тээврээр Улаанбаатар хот руу тээвэрлэгдэнэ.	
3.	15.00-20.00	Дараагийн өдрийн цус цуглуулах үйл ажиллагааны бэлтгэл, доноруудад мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийнэ	
3.	14.30-15.30	Хөшигтийн хөндийн онгоцны буудлаас хүлээн авч ЦССҮТ-рүү тээвэрлэх	ДЗБТ-ийн их эмч Д.Наранхүү ҮТ-ийн эрхлэгч Б.Оргил ИТ-ийн жолооч Б.Энхбат

Аяны үр дүн:


- Донорын тухай хуулийн хэрэгжилт хангагдана.
- Хүн амын дунд авлагагүй, сайн дурын цусны донорын талаарх мэдлэг, хандлага сайжирч байнгын донорын тоо, эзлэх хувь нэмэгдэнэ.
- Жил бүр өсөн, хурдацтай нэмэгдэж буй эмнэлгийн захиалгыг бүрэн хангах, цус цусан бүтээгдэхүүний байнгын нөөц бүрдүүлж, өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн бэлэн байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2024 оны 03 дугаар сарын 12-ны
өдрийн 1119... дүгээр тушаалын
2 дугаар хавсралт



Цусны нөөц бүрдүүлэх багийн бүрэлдэхүүн

Багийн ахлагч:	Б.Ижилбаатар	ДЗБТ-ийн технологич их эмч
Багийн гишүүд :	Ё.Улсболд	ДЗБТ-ийн технологич их эмч
	Б.Одонтунгалаг	ДЗБТ-ийн технологич их эмч
	Р.Энхтуяа	ДЗБТ-ийн донор зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн
	Х.Чулуунцэцэг	ДЗБТ-ийн технологич сувилагч
	Э.Дашгарав	ДЗБТ-ийн технологич сувилагч
	Д.Одмаа	ДЗБТ-ийн технологич сувилагч
	Н.Батцэрэн	ДЗБТ-ийн технологич сувилагч
	Д.Сарантуяа	ДЗБТ-ийн технологич сувилагч
	Б.Есүүн	ДЗБТ-ийн технологич сувилагч
	Э.Мөнхтуяа	ДЗБТ-ийн технологич сувилагч
	Б.Анударь	НЛТ-ийн лаборант
	О.Ариунхүслэн	НЛТ-ийн Био-анагаахын мэргэжилтэн
	Ч.Далайцэрэн	ЭШМТА-ны мэдээллийн технологийн инженер
	Н.Давааням	ИТТ-ийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, цацрагийн аюулгүй байдлын ажилтан
	Ж.Эрхэмбаяр	ИТТ-ийн сантехникийн слесарь, туслах ажилтан



БАГИЙН АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

№	Нэрс	Албан тушаал	Хариуцах чиг үүрэг
1.	Б.Ижилбаатар	Технологич их эмч	<ul style="list-style-type: none">Алсын явуулаар цус цуглуулахад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал, цус тээвэрлэх сав, донорын хоол хүнсний бэлэн байдлыг хангаж, хяналт тавьж ажиллана.Оюу толгой ХХК-ний бие төлөөлөгч нартай ЦССҮТ-ийг төлөөлөн харилцаж, шаардлагатай асуудлыг Ерөнхий захиралд тухай бүр танилцуулан ажиллана.Багийг ахалж, гишүүдийг хариуцсан чиг үүргийн дагуу дэг журамтай ажиллуулах, ажиллагсадын аюулгүй байдлыг хангаж ажиллана.Донорын эрүүл мэндийн үзлэг хийнэ.Бүтээгдэхүүний аюулгүй байдал түр хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааг хариуцна.
2.	Ё.Улсболд	Технологич их эмч	<ul style="list-style-type: none">Донорын эрүүл мэндийн үзлэг хийнэ.Цусны донорын сонор сэрэмжийн үйл ажиллагааг хариуцна.Шаардлагатай тохиолдолд донорт яаралтай тусламж үзүүлнэ.Бүтээгдэхүүний аюулгүй байдал түр хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааг хариуцна.
3.	Б.Одонтунгалаг	Технологич их эмч	<ul style="list-style-type: none">Донорын эрүүл мэндийн үзлэг хийнэ.Яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангаж ажиллана.Шаардлагатай тохиолдолд донорт яаралтай тусламж үзүүлнэ.Бүтээгдэхүүний аюулгүй байдал түр хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааг хариуцна.
4.	Р.Энхтуяа	ДЗБ хариуцсан мэргэжилтэн	<ul style="list-style-type: none">Цус өгөхийн өмнө, дараах зөвлөгөө, донорын сургалт, сурталчилгаа мэдээллийн үйл ажиллагааг хариуцна.Цус өгөхийн өмнөх болон дараах донорын цай хүнс олгох үйл ажиллагааг хариуцна.Шаардлагатай тохиолдолд донорт яаралтай тусламж үзүүлнэ.
5.	Х.Чулуунцэцэг	Технологич сувилагч	<ul style="list-style-type: none">Алсын явуулаар цус цуглуулахад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал, цус тээвэрлэх
6.	Э.Дашгарав	Технологич сувилагч	

7.	Д.Одмаа	Технологич сувилагч	сав, донорын хоол хүнсний жагсаалт гарган, бэлтгэж, цус цуглуулах бэлэн байдлыг хангана. <ul style="list-style-type: none"> • Донороос цус авна. • Цусны донорын сонор сэрэмжийн тогтолцоог хэрэгжүүлнэ • Донорт яаралтай тусламж үзүүлнэ. • Бүтээгдэхүүний аюулгүй байдал түр хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааг хариуцна.
8.	Н.Батцэрэн	Технологич сувилагч	
9.	Д.Сарантуяа	Технологич сувилагч	
10.	Б.Есүүн	Технологич сувилагч	
11.	Э.Мөнхтуяа	Технологич сувилагч	
12.	Ч.Далайцэрэн	МТ-ийн инженер	<ul style="list-style-type: none"> • Донорын цахим бүртгэлийг хийнэ. • Цахим сүлжээ, шаардлагатай компьютерын бэлэн байдлыг хангаж ажиллана.
13.	Н.Давааням	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, цацрагийн аюулгүй байдлын ажилтан	<ul style="list-style-type: none"> • Донорын цахим бүртгэлийг хийнэ. • Шаардлагатай тоног, төхөөрөмжийн жагсаалтыг гаргаж, бэлэн байдлыг хангаж ажиллана.
14.	Б.Анударь	Лаборант	<ul style="list-style-type: none"> • Цус цуглуулахын өмнөх шинжилгээг хийнэ. • Сорьц түр хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаа аюулгүй байдлыг хариуцаж ажиллана.
15.	О.Ариунхүслэн	Био-Анагаахын мэргэжилтэн	
16.	Ж.Эрхэмбаяр	Сантехникийн слесарь, туслах ажилтан	<ul style="list-style-type: none"> • Цус өгөхийн өмнө, дараах хүнс, цайны материалын бэлэн байдал, аюулгүй байдлыг хангаж ажиллана. • Доноруудад цай, хүнсийг олгоно. • Цахилгааны хэрэгсэл аюулгүй байдлыг хариуцаж ажиллана.